



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 02-өдөр

Дугаар А/503

Мөрөн сум

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 27 дугаар зүйл, 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1, Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Авлигатай тэмцэх газрын Мөрдөгчийн 2023 оны 09 дүгээр сарын 20-ний өдрийн №107 “Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах тухай” мэдэгдлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 6 дугаар баг “Жаст ойл”-ын хажууд байрлах “Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор” зориулалттай 376 мкв хэмжээтэй газрыг Иргэн Б.Хаш-Эрдэнэд дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтгүйгээр хууль бусаар эзэмшүүлсэн нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тул аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны А/97 “Газар эзэмшүүлэх тухай” захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

2. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ